



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/32

Ховд

Орон нутгийн өмчийн газрыг өөрчлөн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Худалдан авах ажиллагааны албыг татан буулгаж, аймгийн Орон нутгийн өмчийн газартай нэгтгэн Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллагааны албатай/-ыг өөрчлөн байгуулсугай.
2. Байгууллагын болон албан хаагчдын чиг үүргийн шинжилгээг “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу хийж, чиг үүргийн давхардал, хийдэл үүсэхгүй байхаар оновчтой зохицуулан, байгууллагын бүтэц, тоог 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан батлуулж, байгууллагын чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Нохойжав/-д даалгасугай.
3. Аймгийн Засаг даргын “Бүтцийг өөрчлөх тухай” 2020 оны А/873 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



8400 01 0240
Zah A/32 Kh